



ЗАЛУУ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ САНААЧЛАГА ХӨТӨЛБӨР

Development Solutions NGO became an accredited member of the Youth Business International (YBI) network in 2012 and launched the Youth Business Mongolia (YBM) program. YBI aims to build a sustainable and inclusive entrepreneurship ecosystem to support young entrepreneurs. Under its 2023–2025 strategy, YBI targets supporting 750,000 young entrepreneurs, creating 1 million jobs, and enabling 250,000 businesses to start and grow.

The mission of YBM is to provide motivated and aspiring entrepreneurs aged 18–35 with the necessary support to start, grow, and succeed in environmentally and socially responsible businesses. The program offers a wide range of services, including tools, training, advisory, mentoring, access to finance, and business networks, particularly targeting youth in remote, underserved, and vulnerable groups.

YBM has organized various initiatives such as green and social business training series, women entrepreneurs' leadership programs, monthly mentor breakfast meetings, and social entrepreneurship forums. With the support of YBI, YBM reached over 3,000 young entrepreneurs in Mongolia in 2023 who are committed to developing innovative, effective, and impactful businesses.

As a result, 2,630 youth participated in entrepreneurship training, 321 businesses accessed finance, and 336 youth were connected with mentors and coaches. On average, each supported business created 2.16 full-time jobs. In addition, 71 new businesses were established, and 410 businesses were supported to scale and grow.

Хөгжлийн Шийдэл ТББ нь 2012 онд Залуучуудын Бизнесийн Олон Улсын Сүлжээ (Youth Business International-YBI) байгууллагын итгэмжлэгдсэн гишүүн болсоноор Залуучуудын Бизнес Санаачилга (Youth Business Mongolia - YBM) хөтөлбөрийг эхлүүлэв. YBI нь энтрепренер залуучуудыг дэмжих зорилгоор тогтвортой, хүртээмжтэй бизнес эрхлэх экосистемийг бий болгоход чиглэдэг. YBI-ийн 2023-2025 оны стратегийн хүрээнд 750,000 энтрепренер залуучуудыг дэмжих замаар нэг сая ажлын байр бий болгож, 250,000 бизнесийг шинээр эхлүүлэх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой юм. YBM хөтөлбөрийн эрхэм зорилго бол 18-35 насны урам зоригтой, хүсэл эрмэлзэлтэй бизнес эрхлэгчдийг нийгэм, байгаль орчинд ээлтэй замаар гарааны бизнес, өсөлт, амжилт гаргахад шаардлагатай дэмжлэгээр хангах явдал юм. Бид алслагдсан, хүртээмжээс гадуур, эмзэг бүлгийн залуучуудад зориулсан хэрэглэгдэхүүн, сургалт, зөвлөгөө, менторинг, санхүүгийн хүртээмж, бизнесийн сүлжээг бий болгох зэрэг олон төрлийн бизнес эрхлэлтийг дэмжих үйлчилгээг санал болгодог. Нийгмийн болон ногоон бизнесийг дэмжих цуврал сургалт, энтрепренер эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр, сар бүрийн менторуудын өглөөний уулзалт, нийгмийн энтрепренерүүдийн чуулган зэрэг арга хэмжээ, үйл ажиллагаануудыг зохион байгуулсан. Энэ бүхнийг YBI-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж, 2023 онд шинэлэг, шилдэг, үр дүнтэйгээр бизнесээ хөгжүүлэх хүсэлтэй Монголын 3,000 гаруй залуучуудыг дэмжин ажилласан юм. Үүний хүрээнд, 2,630 залуус энтрепренершипийн сургалтад хамрагдаж, 321 бизнес санхүүжилтэд холбогдож, 336 залуус ментор болон көүчүүдтэй болсоноор нэг бизнест дунджаар бүтэн цагийн 2.16 ажлын байрыг бий болгосон. Мөн 71 бизнес шинээр эхлүүлэхэд, 410 бизнесийг өргөжин хөгжихөд тусгайлан дэмжин ажилласан.

